



2024 оны 01 дүгээр сарын 10

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

Ажлын зорилго: Монгол Улсаас Америкийн Нэгдсэн Улс руу тогтмол агаарын тээврийн нислэг үйлдэх бэлтгэл ажлын хүрээнд Монголын Иргэний нисэхийн ерөнхий газар нь АНУ-ын Холбооны нисэхийн захиргаа /FAA/-ны Нисэхийн аюулгүй байдлын олон улсын аудит /IASA/ шалгалтад амжилттай хамрагдахад мэргэжлийн зааварчилгаа авах, бэлтгэл ажлыг хангуулахад зөвлөх үйлчилгээ болон техникийн туслалцаа авах.

Хугацаа: 6 сар

Байршил: Иргэний нисэхийн ерөнхий газар, Улаанбаатар хот, Монгол Улс

ОРШИЛ

“МИАТ” ТӨХК нь АНУ руу шууд нислэг үйлдэж эхлэхээр төлөвлөөд байгаа бөгөөд АНУ-ын Холбооны нисэхийн захиргаа нь тус улс руу нисэх зөвшөөрлийг олгоходоо хүсэлт гаргасан агаарын тээвэрлэгчид бус тухайн агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ олгогч Улсын нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагад аудит шалгалт хийж, CAT 1 үнэлгээ авснаар Монгол Улсын агаарын тээвэрлэгчид Хойд Америк руу хуваарыт нислэг үйлдэх эрх нээгдэх юм.

АНУ-ын Холбооны нисэхийн захиргаанаас хийж гүйцэтгэх Нисэхийн аюулгүй байдлын аудит /IASA/ нь Олон улсын Иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын дараах хавсралтуудад тусгасан аюулгүй ажиллагааны стандартын хэрэгжилтийг ICAO Doc 9734 (Аюулгүй байдлын хяналтын заавар)-д заасан аюулгүй ажиллагааны хяналтын тогтолцооны чадамжийг үнэлэх шалгуурын дагуу шалгаж аюулгүй ажиллагааны зэрэглэл (CAT1 болон CAT2) тогтоодог:

- Хавсралт 1 - Ажилтны үнэмлэх
- Хавсралт 6 - Агаарын хөлгийн үйл ажиллагаа
- Хавсралт 8 - Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар

ҮНДЭСЛЭЛ

- Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболдын 2023 оны 01 дүгээр сарын 22-28-ны өдрүүдэд АНУ-д ажилласны дагуу хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний 12 дугаар заалт;
- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/281 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт;
- U.S. Code of Federal Regulations (CFR) Part 211 - Applications for permits to foreign air carriers, Part 302 Subpart B - Rules Applicable to U.S. Air Carrier Certificate and Foreign Air Carrier Permit Licensing Proceedings, Part 129 - Foreign air carriers and foreign operators of U.S.-Registered aircraft engaged in common carriage;
- FAA AC 129-5. Provision of Technical Assistance to Civil Aviation Authorities for Safety Oversight of International Commercial Air Transportation Including by Commercial Technical Assistance Providers.

АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын үйл ажиллагаанд IASA протокол асуултуудын дагуу үнэлгээ хийх;
2. Үнэлгээнд үндэслэн дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулах, хамтран хэрэгжүүлэх, төлөвлөгөөгөөр боловсруулах шаардлагатай баримт бичгийн төслийд боловсруулах;
3. Нисэхийн аюулгүй ажиллагааны бодлого, зорилтууд ба тэдгээрт нийцсэн чиг үүрэг бүхий бүтэц зохион байгуулалт, удирдах ажилтнуудын аюулгүй ажиллагааны чиг үүрэг, хууль эрх зүйн тогтолцоо, ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх сургалтын хэрэгцээ, хүний нөөцийн менежментийн тогтолцоо, ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах талаар, аюулгүй ажиллагааг хангахад тулгамдаж байгаа асуудлууд, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх талаар нарийвчилсан судалгаа хийж үндэслэл бүхий зөвлөмж өгөх;
4. Хувь хүний үнэмлэхжүүлэлт, агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын хадгалалт болон агаарын тээврлэгчийн гэрчилгээжүүлэлтийн үйл явцад үнэлэлт өгөх, үйл ажиллагааны заавар, журмуудыг шинэчлэх, шинээр боловсруулах шаардлагатай зохицуулалтын баримт бичгүүдийг тодорхойлон тэдгээр баримт бичгийн төслийг бэлтгэж өгөх;
5. FAA IASA аудит шалгалтад хамрагдахад зааварлах, хамтран ажиллаар;
6. Шаардлагатай тохиолдолд, FAA IASA аудит шалгалттай холбоотой асуудлаар Монголын ИНЕГ-ын зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн хувиар АНУ-ын Төрийн байгууллагуудтай холбогдож зуучлах, ёмгөөлөх.

Ажлын даалгаврын задаргаа:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын одоогийн байдлыг тодорхойлох зорилгоор IASA

протокол асуулгуудын дагуу бүрэн хэмжээний аudit шалгалтыг гүйцэтгэж, илэрсэн үл нийцлүүдийг хэрхэн засах, сайжруулах зөвлөмжийг өгөх;

2. Монгол Улсын эрх зүйн баримт бичгүүд, тэдгээрийн тогтолцоог судалж үнэлэх, нэмэлтээр шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг тодорхойлох, одоо мөрдөгдөж байгаа баримт бичгүүдийг сайжруулах талаар зөвлөмж өгөх;
3. Иргэний нисэхийн ерөнхий газрын удирдах ажилтнуудын аюулгүй ажиллагааны чиг үүргүүдийг судалж, тодорхойлох;
4. Иргэний нисэхийн бүтэц зохион байгуулалтын судалгааг хийж, аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж болохуйц бүтцийн саналыг Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт, зөвлөмж, аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо, ижил төстэй бусад улсын иргэний нисэхийн байгууллагын бүтэц, чиг үүрэгтэй харьцуулан судалж, санал боловсруулах;
5. Иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагааг цахимжуулах боломж, технологийн шийдлүүдийг судалж, танилцуулах, зөвлөмж өгөх;
6. Иргэний нисэхийн хүний нөөцийн менежментийг тогтолцоог судалж, хэрэгжилтэд үнэлгээ хийж, хүний нөөцийг бүрдүүлэх, хадгалж тогтоон барих, тогтвортой ажиллуулахад тулгарч байгаа үндсэн асуудлуудыг тодорхойлж, запруулах талаар зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний санал боловсруулах;
7. Иргэний нисэхийн ерөнхий газрын байцаагч, мэргэжилтнүүдийн ур чадварыг үнэлэх, сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, сургалтын тогтолцоог хэрхэн бүрдүүлэх талаар санал боловсруулах, сургалтын дутагдлыг нөхөх төлөвлөгөө боловсруулах, шаардлагатай сургалт зохион байгуулах;
8. Хувь хүний үнэмлэхжүүлэлт, агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын хадгалалт болон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлтийн үйл явцад үнэлэлт өгөх;
9. Монгол Улсын нисэхийн аюулгүй ажиллагааны үндэсний төлөвлөгөөг гаргахтай холбоотойгоор иргэний нисэхийн салбарын тулгамдсан асуудлуудын судалгааг хийж, төлөвлөгөөний төслийг боловсруулах;
10. Протокол асуулгын үр дүн болон иргэний нисэхийн салбарын хэмжээнд хийгдсэн судалгааг үндэслэн тайлан боловсруулж, зөвлөмжийг өгөх;
11. Протокол асуулгын үр дүн болон иргэний нисэхийн салбарын хэмжээнд хийгдсэн судалгааг үндэслэн Залруулах ажлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд хамтран ажиллах;
12. Нисэхийн аюулгүй ажиллагааны үндэсний төлөвлөгөөний төсөл, зөвлөх үйлчилгээний нэгдсэн тайлан болон түүнд тусгагдсан

зөвлөмжүүд, залруулах ажлын төлөвлөгөөг ИНЕГ-ын даргад танилцуулах;

13. FAA IASA аудит шалгалтад хамрагдах явцад зааварлах, хамтран ажиллах;
14. Шаардлагатай тохиолдолд, FAA IASA аудит шалгалттай холбоотой асуудлаар Монголын ИНЕГ-ын зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн хувиар АНУ-ын Төрийн байгууллагуудтай холбогдож зуучлах, өмгөөлөх, дэмжлэг үзүүлэх.

Зөвлөхөд тавигдах шаардлага:

Зөвлөхөд дараах шаардлага тавигдана:

- Тендер сонгон шалгаруулалтад оролцох байгууллага өмнө нь FAA IASA аудитад бэлтгэхтэй холбоотой Иргэний нисэхийн удирдах газарт зөвлөх үйлчилгээг амжилттай үзүүлж байсан олон жилийн туршлагатай байх;
- Холбооны улсын нисэхийн дүрэм 129, Холбооны нисэхийн захиргааны 2003 оны Зөвлөмжийн цуврал 129-5 шаардлагыг хангасан байх;
- Тухайн байгууллагын зөвлөхүүд нь иргэний нисэхийн төрийн хяналт, зохицуулалтын чиглэлээр 7-оос доошгүй жил ажилласан туршлагатай нисэхийн ажилтнуудаас бүрдсэн байхаас гадна хуульч, дата боловсруулагч нар багтсан байна.
- Нисэхийн зөвлөх үйлчилгээний чиглэлээр 10-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан байна.

БОЛОВСРУУЛЖ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ МАТЕРИАЛЫН ИЖ БҮРДЭЛ:

1. Зөвлөх үйлчилгээ, техникийн туслалцааны тайлан, зөвлөмжүүдийн хамт;
2. Залруулах ажлын төлөвлөгөөний төсөл, хэрэгжилтийн гүйцэтгэлийн тайлан;
3. Аудит шалгалтад хамрагдах нарийвчилсан төлөвлөгөө, зааварчилгаа;
4. Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны үндэсний төлөвлөгөөний төсөл;
5. Шаардлагатай бусад баримт бичгийн төсөл.

АЖЛЫН ДААЛГАВАР ХЯНАСАН:

НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, НИСЛЭГТ ТЭНЦЭХ ЧАДВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТЫН АХЛАХ БАЙЦААГЧ

Б.ХҮДЭРЧУЛУУН

АЖЛЫН ДААЛГАВАР БОЛОВСРУУЛСАН:

АЭРОДРОМ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТЫН АХЛАХ БАЙЦААГЧ

Г.МОНХБОЛД

НИСЛЭГИЙН СТАНДАРТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН АХЛАХ БАЙЦААГЧ

Ч.ДАРЬСҮРЭН